



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№188 /398/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.10.19

Цаг үе, үйл явдал

“ЯВГАН ХҮНИЙ ГАРЦ” ХЭСЭГЧИЛСЭН АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛЖ БАЙНА



хүчний хяналтын хариуцсан дэвсгэрийн гарц гарам дээр ажиллаж явган зорчигчдыг гарц гармаар гарахдаа баруун гар талаа барьж нэвтрэх, жолооч нарыг гарц гарамд ойртон ирэхдээ хурдаа хасаж замын хөдөлгөөнд анхаарал болгоомжтой оролцох, Замын хөдөлгөөний дүрмийг мөрдүүлэхэд хяналт тавьж, илэрсэн зөрчлүүдэд хариуцлага тооцон ажиллажээ. Тус арга хэмжээний хүрээнд ҮБХИС, Цэргийн төв эмнэлгийн алба хаагчдад шатаар өгсөж, уруудахдаа болон хонгилоор явахдаа баруун гар талаа барьж явах дадал зуршил төлөвшүүлэх сургалтыг зохион байгуулсан аж.



Тээврийн албаныхан нутаг дэвсгэрийн явган хүний гарц гарам дээр ажиллаж явган зорчигчдыг гарц гармаар гарахдаа баруун гар талаа барьж нэвтрэх, жолооч нарыг гарц гарамд ойртон ирэхдээ хурдаа хасаж замын хөдөлгөөнд анхаарал болгоомжтой оролцох, Замын хөдөлгөөний дүрмийг мөрдүүлэхэд хяналт тавьж, илэрсэн зөрчлүүдэд хариуцлага тооцон ажиллажээ. Тус арга хэмжээний хүрээнд ҮБХИС, Цэргийн төв эмнэлгийн алба хаагчдад шатаар өгсөж, уруудахдаа болон хонгилоор явахдаа баруун гар талаа барьж явах дадал зуршил төлөвшүүлэх сургалтыг зохион байгуулсан аж.

Зам тээврийн хангуулах чиглэлээр осол зөрчлөөс "Явган хүний гарц" урьдчилан хэсэгчилсэн арга сэргийлэх, замын хэмжээг зохион хөдөлгөөний байгуулж байна. аюулгүй байдлыг Зэвсэгт

ЦАГ АГААР

УЛААНБААТАР	
ӨДӨР	ШӨНӨ
☀️ 13	☁️ -1

ӨМНӨД СУДАН	
ӨДӨР	ШӨНӨ
☀️ 33	☁️ 23

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3.415.00	3.428.0
EUR 🇪🇺	3.340.0	3.360.0
CNY 🇨🇳	475	480
RUB 🇷🇺	51.40	51.90
JPY 🇯🇵	23.30	24.10
KRW 🇰🇷	2.43	2.47

ЗУРХАЙ

2022.10.19 /ЛХАГВА ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 24

НАМРЫН ДУНД САРЫН ШАРАГЧИН ТАХИА САР НАЙМАН ЦАГААН ХӨХӨГЧИН МОГОЙ ӨДӨР

Үс засуулбал:
Өвчин эмгэг ирнэ
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
07.17-17.58
Барилдлага:
Рашаан
Шүтэн барилдлага:
Мунхрахуй

РОТЫН ЖИГДРЭЛТИЙН ШАТНЫ СУРГАЛТ ЭХЭЛЛЭЭ



Бүгд Найрамдах Өмнөд Судан Улсад үүрэг гүйцэтгэхээр ажиллагааны өмнөх сургалтаа хангаж буй Монгол Улсын Зэвсэгт хүчний 12 дугаар ээлжийн Мотобуудлагын батальоны бие бүрэлдэхүүнтэй явуулах ротын жигдрэлтийн шатны сургалтыг энэ сарын 13-ны өдрөөс 19-ний өдрүүдэд төлөвлөн зохион байгуулж байна.

Энэхүү ротын жигдрэлтийн шатны сургалтын явцад ротын удирдлагын удирдан зохион байгуулах үр чадварыг нэмэгдүүлэн, БНӨСУ-ын энгийн ард иргэдийг хамгаалах, хүмүүнлэгийн тусламжид дэмжлэг үзүүлэх зэрэг үүргүүдийг салбарын бүрэлдэхүүнээр бие даан үүрэг гүйцэтгэх арга, ажиллагаанд сурган дадлагажуулснаар ротын жигдрэлтийг хангах юм.

Уг сургалтыг амжилттай явуулсны дараа батальоны жигдрэлтийг хангах сургалтыг зохион байгуулахаар төлөвлөөд байна.

Ахлах дэслэгч Л.ТҮМЭНДЭЛГЭР



КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол
Нийт: 630,111,004

Эдгэрсэн
Нийт: 609,382,386

Нас барсан
Нийт: 6,572,515

Цаг үе, үйл явдал

2022-2023 ОНЫ СУРГУУЛИЙН ЖИЛИЙН НЭЭЛТЭЭ ХИЙЛЭЭ



Зэвсэгт хүчний 065 дугаар анги сургуулийн жилийн нээлтийн арга хэмжээг хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу зохион байгуулж жигдрэлтийн дадлага сургуулийг эхлүүлээ. Тодруулбал бие бүрэлдэхүүнийг ангийн захирагчийн баталсан "Удирдамж"-ийн дагуу

цугларалт дохиогоор ажиллуулан бэлэн байдлыг шалгахын зэрэгцээ ЗХЖШ-ын даргын цахим нээлтийн хуралд бүрэн хамруулав. Сургуулийн жилийн нээлтийн үеэр ангийн захирагч хурандаа Ш.Цэрэнбат бие бүрэлдэхүүнд хандан үүрэг чиглэл өгсөн бол, 2022 оны төгсөгчдийг төлөөлж дэслэгч

Г.Мөнхболд сургуулийн жилийн зорилго, зорилтод нийцүүлэн цэргийн сургалт бэлтгэлийг үр дүнтэй, үүрэг гүйцэтгэх өндөр ур чадвартай, мэргэшсэн цэргийн алба хаагчид болж, Зэвсэгт хүчнээ манлайлан ажиллацгаая хэмээн уриалга дэвшүүлсэн юм.

Үргэлжлүүлэн ахлагчийн бие бүрэлдэхүүнд жагсаалын үзлэгийг явуулсан бөгөөд энэ үеэр ангийн ахлагч, тэргүүн ахлагч Д.Батбаяр "Хувь хүн аливаа тулгарч болох бэрхшээлд хэзээд бэлэн байх ёстой ба аранзны бэлэн байдал, түүн дотор байгаа нэг ширхэг эд зүйлс ч амьдралтай, хэрэглээнд бодитоор нийцсэн байх ёстой" хэмээн анхааруулж амьд гарах арга ухааны хэрэгслийн талаар заавар зөвлөгөөг өгч ажиллалаа.

Мөн төлөвлөгөөний дагуу жигдрэлтийг хангах сургалтын хүрээнд ангийн бие бүрэлдэхүүн тактик тусгай бэлтгэлийн 10 км-ын явган маршийг Улиастай-ҮБХИС-ийн полигоны чиглэлд үйлдэв. Маршийн явцад

бие бүрэлдэхүүний өдрийн хооллолтыг аранзны хүнсээр зохион байгуулсан ба түр амралтын цэгт бүрэлдэхүүний багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэх болон хувь хүмүүсийн IQ, EQ шалгасан хөгжөөнт тэмцээнүүдийг зохион байгуулахад багаар ажиллах төрөлд ахлах ахлагч н.Түмэн-Өлзий захирагчтай 3 дугаар салаа, IQ, EQ шалгах авхаалж,

самбаа шалгасан төрөлд хошууч н.Мөнхболд ахлагчтай 1 дүгээр салааны бүрэлдэхүүн тус тус тэргүүлэв.

Анги 2022-2023 оны сургуулийн жилийг манлайллын жил болгох зорилт дэвшүүлэн ажиллаж Зэвсэгт хүчний үйл ажиллагаа, цэрэг эх оронч үзлийг иргэдэд сурталчлах ажлыг үе шаттай зохион байгуулах юм.

Ахмад Л.САРАНЗАЯА



БУЛГАН АЙМГИЙН СУМ ДУНДЫН ГАР БӨМБӨГИЙН ТЭМЦЭЭНД МАНЛАЙЛАВ



Зэвсэгт хүчний 234 дүгээр анги Булган аймгийн Сэлэнгэ, Хангал сум, Хялганат тосгоны иргэдийн дунд энэ сарын 15-16-ны өдрүүдэд гар бөмбөгийн нөхөрсөг тэмцээн зохион байгуулагдлаа.

Тус тэмцээнд эрэгтэй 8, эмэгтэй 13 баг өрсөлдсөнөөс Зэвсэгт хүчний 234 дүгээр ангийн баг тамирчид манлайллаа. Тодруулбал, шилдэг тэгш тоглогчоор худгийн моторчин Б.Батцэцэг, шилдэг тоглогчоор Б.Сийлэгмаа нар шалгарсан бол багийн дүнгээр нэгдүгээр байрт эмэгтэй тамирчдын баг, гуравдугаар байрт эрэгтэй тамирчдын баг тус тус шалгарлаа.

АМЖИЛТ ДҮҮРЭН СУРАЛЦАХЫГ ЗАХИЛАА



2022-2023 оны сургуулийн жилийн хичээлийн шинэ жилийн нээлтийн арга хэмжээг зохион байгуулах ажлын хүрээнд бие бүрэлдэхүүн "Цугларалт" дохиогоор ажиллаж аранз, хүн нэг бүрийн хэрэгсэл, бичиг баримтын үзлэгт хамрагдсаны зэрэгцээ ЗХЖШ-аас цахимаар зохион байгуулсан нээлтийн арга хэмжээнд оролцлоо. Мөн энэ үеэр ангийн захирагч хурандаа Г.Эрдэнэбаяр 2022-2023 оны сургуулийн жилийн зорилго, зорилт, дээд шатны удирдлагаас баримталж буй бодлогыг танилцуулан, цэргийн алба хаагчдаа амжилт дүүрэн суралцахыг захилаа.

Сургалт

МОНГОЛ БИЧГИЙН ХИЧЭЭЛ №07

ОРХИЦ буюу ЦАЦЛАГА /ЦАЦАЛ/


Орхицыг нурууны гол шугамаас эхлүүлэн баруун доош ялимгүй зураас татаад 45 хэмийн налуутай зүүн доош үргэлжлүүлж үзүүрийг нь дээш өргөсхийн сул орхиж төгсгөдөг.

Өмнөх зурлагаас нь тусад нь салгуу бичдэг А, Э эгшгийг монгол бичигт орхицоор тэмдэглэнэ.

Дөрвөлжин шугамтай дэвтэрт бичихэд, нэг дөрвөлжин нүдний диагоналийн хэмжээтэй буюу түүнээс ялимгүй урт бичнэ. Өргөний хэмжээг таван шугамын эхний шугамаас урагш хэтрүүлэхгүй.

Дармалаар:

Бичмэлээр:



ЭРХ ЗҮЙ АППЛИКЭЙШНЫГ СУРТАЛЧИЛЛАА



Монгол Улсын аймгийн Хангал сумын Цэргийн нийтлэг Хялганат тосгоны улсын дүрмүүдийн өөрчлөлт бүртгэлийн байцаагч болон цэргийн Б.Энхжаргал ангийн алба хаагчид тоон гарын үсэг зүй аппликэйшныг олгох ажлыг энэ сарын нийт цэргийн алба 18-ны өдрөөс эхлүүлэн хаагчдад танилцуулан ажиллаж байна. сурталчиллаа.

Мөн Булган Дэслэгч Ч.ОЮУНЧИМЭГ

АХМАДУУДДАА ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ



БНМАУ-ын баатар, ЗХУ-ын 4 удаагийн баатар, Маршал Г.К.Жуковын нэрэмжит Зэвсэгт хүчний 327 дугаар ангийнхан хөдөлмөр зүтгэл, залуу насаа эл ангид аа зориулсан үе үеийн ахмад дайчдаа авч хүндэтгэл үзүүлээ.

Энэ үеэр ангийн захирагч хурандаа Н.Цэцэнхүү эх орноо

батлан хамгаалах үйлсэд залуу, халуун насаа зориулж, хоёргүй сэтгэлээр зүтгэсэн ахмад дайчдаа талархал дэвшүүлэхийн зэрэгцээ "Ардын хувьсгалын 100 жил", Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэж хөгжсөний 100 жилийн ойн медаль болон дурсгалын зүйл гардуулав.

Хошууч Д.ГАНБААТАР